

Хичээл №4


Зүүн Ази ба Өмнөд Азийн улс орнуудын эрт, эдүүгээгийн хувцас

Clothing from the ancient and modern countries of East Asia and South Asia
(East Asia: Korea, Japan, China & South Asia: India, The Himalayan Kingdoms)

Зүүн Ази:

Утгын сүлжээ – 3


“Солонгос үндэсний хувцасны холбоо хамаарал”



Та “Солонгос үндэсний хувцасны холбоо хамаарал” утгын сүлжээнд өгөгдсөн зургуудын хоорондын утгын хамаарлыг хөөн судалснаар солонгос үндэсний хувцас нь бүс нутгийн бусад улс үндэстний хувцастай ямар хамааралтай болон өрнө дахины урлаг судлаачдын анхааралд хэрхэн өртөж, шуугиан тарьсан тухай зэрэг олон сонирхолтой мэдээлэлтэй танилцах явцдаа солонгос хувцасны нэр төрөл, хэрэглээ түүхэн цаг үе бүрт хэрхэн хувьсаж, өнөө үед уламжлагдан ирсэн, орчин үеийн хэрэглээний тухай, дизайнерууд хэрхэн хөгжүүлж байна, цаашдын чиг хандлага ямар байх бол гэх мэтийг өөрсдийн оюун ухаан, үзэл бодлоороо шүүн тунгааж ойлгох болно.

Утгын сүлжээ - 4

Кимоно бол Япон соёлын дархлаа



“Кимоно бол Япон соёлын дархлаа” утгын сүлжээтэй ажилсанаар япон үндэсний соёлын дархлаа болсон цайны ёслол, кимоно өмсөх ёслол зэргээр дамжуулан япончууд үндэснийхээ хувцсыг хэрхэн урлагийн бүтээлийн хэмжээнд хөгжүүлж, соёлын бусад элементүүдээр дамжуулан уламжлан авч явж буй сайхан үлгэр жишээг ойлгож мэдэх явцдаа хичээлийн гол зорилгоо биелүүлнэ.

Өмнөд Ази:

Утгын сүлжээ - 5



Энэтхэгийн хойг болон Энэтхэг орны газар нутаг бол эртний соёл иргэншил үүсэн цэцэглэсэн өлгий нутгуудын нэг бөгөөд Индийн соёл иргэншлийн гол төв нь байсан. Мөн түүхийн ихэнх үед худалдааны замын зангилаа болж, суурин иргэншил, соёл, Хиндү, Будда, Сикхи, Жайна дөрвөн шашин үүсч цэцэглэн хөгжсөн. Түүнчлэн Монгол удмын хаад язгууртнуудын хосгүй үнэт дурсгалууд ч одоо хүртэл байдаг төдийгүй тэдний бахархал болж, дэлхийн өнцөг булан бүрээс олон мянган хүн тэдгээрийг үзэхээр жуулчилж, Энэтхэгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсаар байгааг *Утгын сүлжээтэй ажиллахдаа анхаараарай.*

Утгын сүлжээ - 6

**“Бутанчууд малгай, гутал өмсдөггүй юм болов уу?”
Утгын сүлжээтэй ажиллаж, асуултанд хариулаарай!**



Жич: 2-р нүдний зураг дээрх хүмүүс бол Бутаны сайд нарын зөвлөлийнхөн.

Бутаны тухай хүн бүр л буурай хөгжилтэй, шашинд нэрвэгдсэн гэдгээс өөрөөр мэддэггүй шүү дээ. Тэгвэл бид утгын сүлжээтэй ажиллахаас өмнө тэдний өнөөгийн байдлын гэрэлтэй гэгээтэй талтай танилцах нь зүйтэй.

Өмнөд Азийн орнуудын дотор Бутан улс эдийн засгийн эрх чөлөө, бизнес эрхлэхэд амар амгалан, энх тайван байдлаараа тэргүүлдэг бөгөөд 2016 оны байдлаар энэ бүс нутгийн хамгийн бага авлигад өртсөн орон болжээ. Бутан хөгжил муутай орон хэвээрээ байгаа ч 2023 он гэхэд энэ статусаа төгсгөх төлөвтэй байгаа нь сүүлийн хорин жилийн эдийн засгийн өсөлтөөс нь харагдаж байгаа ажээ. 2008 оны байдлаар Бутан нь нэг хүнд ногдох орлогоороо Энэтхэгээс бараг хоёр дахин их буюу нэг хүнд ногдох орлого нь 1900 доллар болсон байна. 2008 онд Энэтхэгийн нэг хүнд ногдох орлого нь 1070 доллар байжээ.

Утгын сүлжээ - 7

Доорх утгын сүлжээтэй ажиллаж, Нипал улсыг бүрдүүлж буй олон үндэстэн угсаатнуудын хувцас хэрхэн нэгдэж, нэг хэв маягтай болж төлөвшсөнийг олж тогтоогоорой!



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.

АМЖИЛТ ХҮСЬЕ!

Даалгавар авах хаяг: bamuugii@gmail.com